

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/130/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/176
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Л.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв буурч батлагдсан нь байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, санхүүжилт, орлогын эх үүсвэрийг зөв зохион байгуулан, нэн тэргүүнд эмч, ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх, эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг бууруулах зэрэг арга хэмжээг авч ажиллах талаар Эрүүл мэндийн яамны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 2/4931 дүгээр албан бичгээр ажлын чиглэл ирсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалж 2025 оны 10, 11, 12 дугаар сарын 115,363.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй авлага үүссэн байна.

Аудитын гол асуудал

“Мед импекс интернишнл” ХХК-наас хандив тусламжаар 18,040.0 мянган төгрөгийн шүдний иж бүрэн сандлыг өгч, сумын хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний нэгэн төрөл болох шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай өрөөтэй болсон байна.

Бусад асуудлын хэсэг

4126020205

**Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.6 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	300,167,796.41	267,007,300.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,879,135.06	90,414,015.19
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,879,135.06	90,414,015.19
3121	Төгрөг	11,879,135.06	90,414,015.19
31211	Төрийн сангийн харилцах	11,879,135.06	90,414,015.19
33	АВЛАГА	213,261,519.49	115,363,811.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	116,000.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	170,181,619.49	115,363,811.77
335	Бусад авлага	42,963,900.00	-
33510	Байгууллагаас авах авлага	39,973,900.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,990,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	75,027,141.86	61,229,473.65
351	Түүхий эд материал	26,062,209.50	17,647,747.34
35130	Эм боох материал	26,062,209.50	17,647,747.34
354	Хангамжийн материал	48,964,932.36	43,581,726.31
35410	Бичиг хэргийн материал	3,149,500.00	2,896,250.00
35420	Аж ахуйн материал	377,300.00	1,261,500.00
35460	Хүнсний материал	2,854,135.00	7,157,330.00
35470	Бусад хангамжийн материал	42,583,997.36	32,266,646.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	512,049,442.29	527,418,159.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512,049,442.29	527,418,159.54
39100	Газар		
392	Биет хөрөнгө	495,195,442.29	510,564,159.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	334,496,891.28	334,496,891.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,310,186.32)	(66,861,884.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,030,000.00	56,030,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,156,000.08)	(38,859,000.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,736,113.01	251,371,291.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,132,570.70)	(72,956,926.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,435,552.88	62,851,188.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,689,216.73)	(17,230,148.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,236,000.00	2,236,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(451,141.05)	(513,252.21)
393	Биет бус хөрөнгө	16,854,000.00	16,854,000.00
39301	Програм хангамж	530,000.00	530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(530,000.00)	(530,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,854,000.00	16,854,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	812,217,238.70	794,425,460.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,000.00	-

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

413	Өглөг	38,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	38,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	812,179,238.70	794,425,460.15
51	Засгийн газрын хувь оролцоо	93,806,679.93	93,806,679.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,806,679.93	93,806,679.93
51101	Өмч: - төрийн	93,806,679.93	93,806,679.93
512	Хуримтлагдсан үр дүн	459,035,679.02	441,281,900.47
51210	Өмнөх үеийн үр дүн	299,428,258.02	459,035,679.02
51220	Тайлант үеийн үр дүн	159,607,421.00	(17,753,778.55)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	259,336,879.75	259,336,879.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	812,217,238.70	794,425,460.15

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	981,556,130.66	921,311,778.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,319,663.32	49,294,781.10
120	Нийтлэг татварын бус орлого	67,319,663.32	49,294,781.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	16,986,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	16,986,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	38,569,237.88	21,539,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	26,750,425.44	10,769,681.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	914,236,467.34	872,016,997.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,818,500.00	48,518,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,818,500.00	48,518,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	862,417,967.34	823,498,297.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	862,417,967.34	823,498,297.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	817,504,355.24	934,210,930.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	817,504,355.24	934,210,930.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	814,066,020.57	908,048,745.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,649,517.12	577,369,595.16
210101	Үндсэн цалин	295,981,867.18	577,369,595.16
210102	Нэмэгдэл	173,667,024.44	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,721,417.31	-
210104	Урамшуулал	43,279,208.19	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,245,167.83	74,504,495.16
210201	Тэтгэврийн даатгал	45,565,982.35	50,641,324.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,428,275.19	5,979,995.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,712,914.41	3,183,525.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,497,251.33	2,867,299.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,040,744.55	11,832,352.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,855,549.33	42,818,515.21
210301	Гэрэл, цахилгаан	4,793,810.33	6,068,307.21
210302	Түлш, халаалт	36,061,739.00	36,750,208.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,245,226.00	27,636,807.03
210401	Бичиг хэрэг	4,249,300.00	4,210,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,642,950.00	15,986,207.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,940,000.00	3,821,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	606,000.00	1,469,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,806,976.00	2,149,300.00
2105	Нормативт зардал	85,921,599.95	70,489,844.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,511,600.95	61,011,839.20
210502	Хоол, хүнс	13,409,999.00	9,478,005.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	2,000,000.00

**Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	1,200,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,747,100.00	4,941,300.00
210702	Дотоод албан томилолт	6,747,100.00	4,941,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,748,582.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	540,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	183,628.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	432,000.00	448,854.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,193,860.34	106,539,606.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,669,010.12	50,362,951.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,524,850.22	56,176,655.69
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,438,334.67	26,162,184.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	25,462,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,476,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,438,334.67	700,184.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,438,334.67	700,184.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	164,051,775.42	(12,899,151.49)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,444,354.42	4,854,627.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,444,354.42	4,854,627.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,444,354.42)	(4,854,627.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	159,607,421.00	(17,753,778.55)

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	750,261,936.85	943,820,805.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,000,000.00	16,986,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,000,000.00	16,986,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	16,986,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	16,986,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	748,261,936.85	926,834,805.42
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,818,500.00	48,518,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,818,500.00	48,518,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	696,443,436.85	878,316,105.42
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	696,443,436.85	878,316,105.42
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	757,027,343.95	853,388,925.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	757,027,343.95	853,388,925.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,589,009.28	827,226,740.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,727,517.12	577,264,660.20
210101	Үндсэн цалин	296,059,867.18	325,651,645.11
210102	Нэмэгдэл	173,667,024.44	208,453,250.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,721,417.31	8,242,000.00
210104	Урамшуулал	43,279,208.19	34,917,764.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,245,167.83	74,531,430.12
210201	Тэтгэврийн даатгал	45,565,982.35	50,512,962.29
210202	Тэтгэмжийн даатгал	5,428,275.19	6,055,235.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,712,914.41	3,013,098.18
210204	Ажилгүйдлийн даатгал	2,497,251.33	2,851,456.92
210205	Эрүүл мэндийн даатгал	10,040,744.55	12,098,676.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,880,165.33	42,818,515.21
210301	Гэрэл, цахилгаан	4,793,810.33	6,068,307.21
210302	Түлш, халаалт	40,586,355.00	36,750,208.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	32,064,850.00	28,091,957.03
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	3,957,050.00
210402	Тээвэр, шатахуун	17,642,950.00	15,986,207.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,238,500.00	3,821,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,874,700.00	4,327,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	-
2105	Нормативт зардал	63,481,509.00	55,608,895.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,012,769.00	41,827,695.94
210502	Хоол, хүнс	13,468,740.00	13,781,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,390,400.00	28,250,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,180,000.00	50,000.00

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,400.00	3,200,400.00
210604	Урсгал засвар	7,010,000.00	25,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,747,100.00	4,941,300.00
210702	Дотоод албан томилолт	6,747,100.00	4,941,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,748,582.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	540,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	183,628.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	432,000.00	448,854.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,044,300.00	13,971,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,044,300.00	13,971,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,438,334.67	26,162,184.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	25,462,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,476,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,438,334.67	700,184.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,438,334.67	700,184.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(6,765,407.10)	90,431,880.13
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,212,900.00	11,897,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,212,900.00	11,897,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,212,900.00	11,897,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,212,900.00	11,897,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(60,212,900.00)	(11,897,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(66,978,307.10)	78,534,880.13
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,857,442.16	11,879,135.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,879,135.06	90,414,015.19

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	299,428,258.02	652,571,817.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	299,428,258.02	652,571,817.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	159,607,421.00	159,607,421.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	459,035,679.02	812,179,238.70
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	459,035,679.02	812,179,238.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	459,035,679.02	812,179,238.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,753,778.55	-17,753,778.55
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,806,679.93	259,336,879.75	441,281,900.47	794,425,460.15

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,117,508,200.00	943,120,620.63	174,387,579.37	84.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,518,700.00	47,818,515.21	700,184.79	98.56
132001	Орон нутгийн төсвөөс	48,518,700.00	47,818,515.21	700,184.79	98.56
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,037,653,000.00	878,316,105.42	159,336,894.58	84.64
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,037,653,000.00	878,316,105.42	159,336,894.58	84.64
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	31,336,500.00	16,986,000.00	14,350,500.00	54.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,336,500.00	16,986,000.00	14,350,500.00	54.21
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,117,508,200.00	864,585,740.50	252,922,459.50	77.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,117,508,200.00	864,585,740.50	252,922,459.50	77.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,092,046,200.00	839,123,740.50	252,922,459.50	76.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	712,565,700.00	577,264,660.20	135,301,039.80	81.01
210101	Үндсэн цалин	358,094,300.00	325,651,645.11	32,442,654.89	90.94
210102	Нэмэгдэл	288,471,400.00	208,453,250.80	80,018,149.20	72.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,000,000.00	8,242,000.00	6,758,000.00	54.95
210104	Урамшуулал	51,000,000.00	34,917,764.29	16,082,235.71	68.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,439,200.00	74,531,430.12	31,907,769.88	70.02
210201	Тэтгэврийн даатгал	75,929,200.00	50,512,962.29	25,416,237.71	66.53
210202	Тэтгэмжийн даатгал	6,780,000.00	6,055,235.96	724,764.04	89.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,780,000.00	3,013,098.18	3,766,901.82	44.44
210204	Ажилгүйдлийн даатгал	3,390,000.00	2,851,456.92	538,543.08	84.11
210205	Эрүүл мэндийн даатгал	13,560,000.00	12,098,676.77	1,461,323.23	89.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,518,700.00	42,818,515.21	700,184.79	98.39
210301	Гэрэл, цахилгаан	6,768,400.00	6,068,307.21	700,092.79	89.66
210302	Түлш, халаалт	36,750,300.00	36,750,208.00	92.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,728,500.00	28,091,957.03	18,636,542.97	60.12
210401	Бичиг хэрэг	6,268,300.00	3,957,050.00	2,311,250.00	63.13
210402	Тээвэр, шатахуун	27,362,600.00	15,986,207.03	11,376,392.97	58.42
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,222,900.00	3,821,500.00	401,400.00	90.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,874,700.00	4,327,200.00	1,547,500.00	73.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	00.00	3,000,000.00	00.00
2105	Нормативт зардал	118,003,700.00	55,608,895.94	62,394,804.06	47.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,268,200.00	41,827,695.94	55,440,504.06	43.00
210502	Хоол, хүнс	20,735,500.00	13,781,200.00	6,954,300.00	66.46
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,200,400.00	38,200,400.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.00
210602	Тавилга	3,200,400.00	3,200,400.00	00.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	4,941,300.00	58,700.00	98.83
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,941,300.00	58,700.00	98.83

**Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,332,000.00	1,748,582.00	583,418.00	74.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	670,000.00	540,100.00	129,900.00	80.61
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	480,000.00	183,628.00	296,372.00	38.26
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	606,000.00	448,854.00	157,146.00	74.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,258,000.00	15,918,000.00	3,340,000.00	82.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,258,000.00	15,918,000.00	3,340,000.00	82.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,462,000.00	25,462,000.00	00.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,462,000.00	25,462,000.00	00.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,986,000.00	16,986,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,476,000.00	8,476,000.00	00.00	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,879,135.06		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90,414,015.19		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 197,104.6 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,650.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй;

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд шилжүүлэн авсан 3,181.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар бүртгэсэн;

Бараа материалын тодруулгын тайланд шилжүүлэн авсан 9,307.4 мянган төгрөгийн материалыг хандив тусламжаар бүртгэсэн.

Нийт 183,066.2 мянган төгрөгийн бараа материалыг сар бүрийн эцэст бөөнд дүнгээр зарлагадан, санхүүгийн тайланд тусгаж, материалын орлого, зарлагын баримтыг бараа материалын тайланд хавсаргаагүй тайлагнасныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2 "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 6,344.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,239.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,104.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 8,291.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 8,175.0 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 5,239.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн: Жолоочийн тооцооны хуудас, шатахууны зарцуулалтын тайлан гаргаж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын

дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. **Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 16 ширхэг 46,282.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэн, бүртгэх.

3. **Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,947.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар журмыг дагаж мөрдөх, зөвлөмж өгөв.

4. **Цалин, урамшуулалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Хөдөлмөрийн чадвараа алдсаны 1,104.8 мянган төгрөгийн тэтгэмжийг 2 алба хаагчдад олгохдоо Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр олгоогүй, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардлаас олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-тай заасантай нийцээгүй байна.

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийг олгох үндсэн цалингийн зардлаас олгож байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,650.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй;	1	1,650.0	1	1,650.0			1	1,650.0		
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд шилжүүлэн авсан 3,181.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар бүртгэсэн;	1	3,181.0			1	3,181.0	1	3,181.0		
Бараа материалын тодруулгын тайланд шилжүүлэн авсан 9,307.4 мянган төгрөгийн материалыг хандив тусламжаар бүртгэсэн..	1	9,207.4			1	9,207.4	1	9,207.4		
Нийт 183,066.2 мянган төгрөгийн бараа материалыг сар бүрийн эцэст бөөнд дүнгээр зарлагдан, санхүүгийн тайланд тусгаж, материалын орлого, зарлагын баримтыг бараа материалын тайланд хавсаргаагүй тайлагнасан.	1	183,066.2			1	183,066.2	1	183,066.2		
Дүн	4	197,104.6	1	1,650.0	3	195,454.6	4	197,104.6		

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	0.00			-	-	1	0.00	-	-	-	-
Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 16 ширхэг 46,282.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	0.00					1	0.00				
Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,947.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	1	0.00					1	0.00				
Хөдөлмөрийн чадвараа алдсаны 1,104.8 мянган төгрөгийн тэтгэмжийг 2 алба хаагчдад олгохдоо Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр олгоогүй, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардлаас олгосон байна.	1	1,104.8					1	1,104.8				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 5,239.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	5,239.6			1	5,239.6						
Дүн	5	6,344.4			1	5,239.6	4	1,104.8	0	0	0	0

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 149 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 20 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 814,608.8 мянган төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 29,500.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ хугацаа хоцорч, зарлагын 29,329.9 мянган төгрөгийн 4 гүйлгээ байршуулаагүй.	1	873,438.7	-	-	1	873,438.7	-	-
Дүн	1	873,438.7	-	-	1	873,438.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	873,438.7			1	873,438.7		



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 44-20810579-ТӨА-2026/130/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 149 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 20 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 814,608.8 мянган төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 29,500.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ хугацаа хоцорч, зарлагын 29,329.9 мянган төгрөгийн 4 гүйлгээ байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Л.Батчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 45-20810579-ТӨА-2026/130/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 5,239,643 /таван сая хоёр зуун гучин есөн мянга зургаан зуун дөчин гурван/ төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар дүгээр сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн дарга Л.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Л.Батчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn